



ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТББ

Энэхүү сонин бичгийг “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь” төслийн хүрээнд “Глоб Интернэшнл” ТББ-аас 2 сар тутамд эрхлэн гаргана.

Энэ дугаарт

Сэтнүүл зүй

ЖИНЭХЭНЭ СЭТГҮҮЛ ЗҮЙН МЭРГЭЖИЛ
Хоёрдугаар нүүр

Өвөөгийн бодрол

БОРЛОГ ҮРЭЭ
Гурав, дөрөвдүгээр нүүр

Хуульчийн булан

АВИЛГАТАЙ ТЭМЦЭХЭД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ОРОЛЦОО
Тавдугаар нүүр

Тэд асууж байна

СЭТГҮҮЛЧДИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ
Зургадугаар нүүр

Шинэ чиг хандлага

ХЭРЭГЛЭГЧТЭЙ ХАРИЛЦАХ МЕНЕЖМЕНТ ГЭЖ ЮУ ВЭ?
Долдугаар нүүр

Далайд дусал

МЭДЭЭЛЭЛ БОЛОН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД
Наймдугаар нүүр

Сонин бичгийг онлайн болон хэвлэмэл хэлбэрээр авч унших сонирхолтой хүмүүс дараах хаягаар холбоо барина уу.

Манай хаяг: Соёлын төв өргөө, Г корпус, 3 давхар, Улаанбаатар 210620-А, Ш/х-28

Утас: Э-шуудан
324627 globe@magicnet.mn
324764 garav@globeinter.org.mn
99276253 bayan@magicnet.mn

Редакцийн зөвлөл:

- Д.Мөнхбүрэн
- Г.Нарангарав
- Х.Цэвлэл

Мэдээ ♦ Мэдээ ♦ Мэдээ

“СОЛОНГОСЫН ХОЙГТ ЭНХ ТАЙВАН ТОГТООЖ, ЭВЛЭРҮҮЛЭХ” СЭДЭВТ БАГА ХУРАЛД ОРОЛЦОО



ОУСХ (Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо IFJ) -ны гүйцэтгэх хорооны гишүүн, “Глоб Интернэшнл” ТББ-ын тэргүүн Х.Наранжаргал 2007 оны 3-р сарын 12-16-нд Өмнөд Солонгосын нийслэл Сөүл хотод болсон “Солонгосын хойгт энх тайван тогтоож, эвлэрүүлэх” сэдэвт бага хуралд оролцлоо. Энэ бага хурлыг ОУСХ болон Солонгосын сэтгүүлчдийн холбоо хамтран зохион байгуулжээ.

Дэлхийн 50 гаруй орны 350 орчим сэтгүүлч бага хуралд оролцсон байна. Төлөөлөгчид хоёр Солонгосыг эвлэрүүлэх, хамтын ажиллагааны бэлэг тэмдэг болсон Умард Солонгосын аж үйлдвэрийн цогцолбор Кисан болон Кунганг ууланд очжээ. “Хьюнда Асан” компани хоёр солонгосын эдийн засгийн хамтарсан бизнест дангаараа оролцож байгаа бөгөөд тус компани Солонгосын түүхэнд шинэ хуудас бичихэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Дэлгэрэнгүйг: <http://www.monitoring.mn/?module=record2&id=179&menuid=3>

ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫГ НЭВТРҮҮЛЭГТЭЭ ТУСГАНА

Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз (МҮОНТ) иргэдийн санаа бодлыг нэвтрүүлэгтээ тусгаж, тэдэнтэй хамтран ажиллах зорилгоор төрийн албан хаагч, ахмад, хүүхдийн төлөөллөөс бүрдсэн олон нийтийн баг байгуулжээ. МҮОНТ-ийн нэвтрүүлгийн талаар санал, шүүмжлэл өгөх үүрэгтэй дээрх хүмүүс 2-р сарын 23-нд уулзаж, дүүрэг хороонд нь тулгарч буй асуудлын талаар нээлттэй санал солилцсон байна.

МҮОНТ-ээр ирэх долоо хоногт нэвтрэх “Нээлттэй хэлэлцүүлгээр” олон нийтийн багийн санал болгосноор анх удаа харъяалалгүй ахмадуудын нийгмийн асуудлыг хэрхэн шийдэх тухай асуудлыг хөндөх гэж байна. Хэлэлцүүлэгт иргэд, олон нийт холбогдох яам тамгын газруудын удирдах ажилтнууд оролцож, санал бодлоо солилцох юм.

Дэлгэрэнгүйг: <http://www.monitoring.mn/?module=record2&id=178&menuid=3>

ОЙН ӨДӨР “ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ БА PR” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛОВ



Монголын Хэвлэлийн Хүрээлэн /МХХ/ 3-р сарын 15-нд байгуулагдсанааа 11 жилийн ойн өдрийг тохиолдуулан “Хэвлэл мэдээлэл ба PR” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн үеэр МУБИС, МУИС-ийн доктор сэтгүүл зүй судлаачид илтгэл тавьж, харилцан санал солилцсон бөгөөд МХХ “Оны шилдэг сэтгүүл зүйн бүтээл”, “Оны шилдэг орон нутгийн сонин”-ы эздэд шагнал гардууллаа.

Дэлгэрэнгүйг: <http://www.monitoring.mn/?module=record2&id=180&menuid=3>

СОНГУУЛИЙН ҮЕЭР ХМ-ИЙН ЗӨВЛӨЛ АЖИЛЛАНА

УИХ-ын сонгуулийн болон Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд заасан дүрэм журам, загвар, маягтын шинээр боловсруулсан төслийг мэргэжлийн байгууллага, шинжээч, иргэний нийгмийн байгууллагаар хэлэлцүүлэх уулзалтыг Сонгогчдын Боловсрол төв 3-р сарын 14-нд Нээлттэй Нийгэм Форумын байранд зохион байгууллаа.

Ажлын хэсгийн хуульчид нийт 14 дүрэм журам, заавар, маягтыг хуульд нийцүүлэн боловсруулж байгаа бөгөөд үүнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл сонгуулийг ажиглах, сурвалжлах журам, Хэвлэл мэдээллийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам орж байна. Эдгээр журмыг боловсронгуй болгоход иргэд, байгууллагын саналыг авч байна.

Дэлгэрэнгүйг: <http://www.monitoring.mn/?module=record2&id=177&menuid=3>

СЭТГҮҮЛЧДИЙН МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙГ ЗӨРЧЛӨӨ.

Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай “Өгөөмөр”, “Тереза эх” зэрэг хүүхдийн асрамжийн газрынхан 03 сарын 04-05-ны өдрүүдэд Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизийн сэтгүүлч Ж.Алтангэрэл, ТВ5 Телевизийн сэтгүүлч Д.Доржмаа нарын мэдээлэл авах эрхийг зөрчлөө.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр зохион байгуулахаар төлөвлөж буй “Монголын үрс эцэг эхтэйгээ” сэдэвт өдөрлөгийн хүрээнд “Гэр бүлээс гадуурх орчинд байгаа болон хараа хяналтгүй хүүхдүүдийн хэрхэн яаж амьдарч байгаа талаар” Монгол Улсын УИХ, Хүүхдийн эрхийн үндэсний төв, Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, ТВ5 Телевизтэй хамтран цуврал нийтлэл нэвтрүүлгүүд бэлтгэж байна. Энэ зорилгын хүрээнд дээрх асрамжийн газруудаар очиж мэдээлэл авах гэсэн Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизийн сэтгүүлч Ж.Алтангэрэл, ТВ5 Телевизийн сэтгүүлч Д.Доржмаа нарыг бүдүүлгээр хөөж мэдээлэл өгөхөөс татгалзсан байна.

Дэлгэрэнгүйг: <http://www.monitoring.mn/?module=record2&id=177&menuid=3>



Сэтгүүл зүй

ЖИНХЭНЭ СЭТГҮҮЛ ЗҮЙН МЭРГЭЖИЛ

Сурвалжлагчийн ажлыг тодорхойлохдоо бид юуны түрүүнд хурдан шаламгай, нарийн нягт, анхааралтай, ажигч гярхай, хөдөлгөөнтэй гэхчилэн... хэрэгтэй үед хэрэгтэй газар байх ур чадварыг онцолдог. Сэтгүүл зүйн хамгийн гол зүйлийн нэг бол сурвалжлагчийн үүрэг билээ. Сонгодог бүх тодорхойлолтоос үзэхэд сурвалжлагч гэдэг нь "Мэдээ цуглуулж, тодорхойлон бичдэг сонин, сэтгүүл, радио, мэдээллийн агентлаг зэрэг газрын ажилтанг хэлнэ" (*Р.Терри Элмор "АНУ-ын олон нийтийн хэрэгслийн үг хэллэгийн толь", 1992*). "Олон нийтийн ашиг сонирхолыг хөндсөн үйл явдал болон шинэ мэдээ баримтыг ажиглах нь" сурвалжлагчийн үүрэгт багтдаг (*"Оросын орчин үеийн сэтгүүл зүйн амьдралын нэвтэрхий толь", М., 1998, 239-р хуудас*). Орчин үеийн сэтгүүл зүйн ихэнх төрөл жанарын адилаар сурвалжлага ч гэсэн ихээхэн өөрчлөгдсөн. "Нийтийн сэтгэл түгшээсэн асуудалд олон нийт дүн шинжилгээ хийхэд ярилцлагыг ашигладаг" бол сурвалжлагыг "үзэл-санаа ёс суртахууны зөрчилд оролцоход ашигладаг" (*187 хуудас*). Энд онцгой сануулгыг дурьдвал: "Амьд сурвалжлага хийхэд хүнд үе тулгараад байна. Сурвалжлагыг хуурамч баримт сэлтээр хүчтэй шахаж байна. Газар дээр болсон үйл явдалд нэвтрэхийн оронд - албан ёсны хэвлэлийн бага хурлаас хийсэн видео бичлэг ашиглаж байна. Бие даан мөрдөн шалгахын оронд - бүгдэд нь нэг мэдээллийг тараадаг. Мөн дээд хэмжээний уулзалт, осол болсон газрын хаягаар мэдээний багийнхныг зөнгөөрөө илгээдэг болоод байна. Идеалист сурвалжлагчид амь нас, нэр хүндээрээ дэнчин тавьж, амьд зургийн хойноос хөөцөлддөг... Харин студид улс төрийн өнгө аясаар төгсгөсөн мэдээг дэлгэцээр цацаж байна" (*"Оросын мэдээ" сонинноос, 30.06.97*).

Гашуун шүүмжлэлийг эс тооцвол энэхүү саналаар цаг үе, үзэл санааны алагчлал, үйл явдал болсон газар, техникийн тоноглолоос үл хамааран "амьд сурвалжлага"-ын хэзээ ч өөрчлөгдөхгүй үнэ цэнийг тов тодорхой үзүүлжээ. Орчин үеийн сурвалжлагчийн ажил нь хэвшмэл ойлголт, загвараас эрс ялгаатай байна. Ямар ч үед хэзээ ч өөрчлөгддөггүй энэ мэргэжлийн гол цөм бол: сурвалжлагч үйл явдлыг 1-р биеэс нүдээр үзсэн мэт дүрслэн бичих ёстой байдаг.

Орчин цагийн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэг сурвалжлагчид уран зохиолын 10 ажилтан ногдож байна. Мэдээлэл гэдэг нь аливаа сонин, сэтгүүл, радио, телевизийн гол үнэт зүйл нь байдаг. Тиймээс ч мэдээллийн хойноос махран хөөцөлддөг, хурц хараатай, зөн совин, шуналтай, амьд мэдээлэлтэй харьцдаг сурвалжлагч хүний үүрэг ямагт нэмэгдсээр байна. Сурвалжлагчид учрах аюул, мэргэжлийн эрсдэл нь мэдээллийн хойноос анчин шиг хөөцөлдөх үүргээс илүү ноцтой бөгөөд төвөгтэй болж байна. Юуны түрүүнд энэ нь сэтгэл зүйн гэмтэл, түүнд тулгарч буй бэрхшээл, хүндрэл юм. Ажлын ачаалал их байдаг ч, энэ нь сурвалжлагчийн ажлын хамгийн хүнд нь биш билээ. Сурвалжлагчийн ажлын сэтгэл зүйн талын зарим зүйл тодорхой байдаг ч, үүнийг бараг судлаагүй гэж хэлэхэд болно. Ажлын шаардлагаар халуун цэг дээр сурвалжлага хийж буй сурвалжлагчдийн аюулгүй байдал, мэргэжлийн ур чадварын чухал нөхцөл нь сэтгэл зүйн хүнд хэцүү байдал, саад тотгор, эрсдэлийн талаарх мэдлэг байдаг.

Сурвалжлагч уншигч, сонсогчийн "чих, нүд" нь байдаг. Илүү ч үгүй дутуу ч үгүй. Өнөө үед энэ нь хамгийн чухал хөрөнгө болохоор илүү ч үгүй гэж тайлбарласан. Хэн боловч өөрөө бодож, сэтгэж, сонгохыг хүсдэг, харин хэрэгтэй газар,

хэрэгтэй үед нь очиж тухайн асуудлыг нарийвчлан асууж, сураглан, тодорхой бичиж харуулах тухайд юу гэх бол...

Сурвалжлагч нь дараах ур чадвартай байна. Үүнд: байнгын харилцаа холбоо, идэвх санаачлага, эр зоригтой, шинэ зүйлийг анзаарах чадвар, хурдан хүлээн авч, шийдвэр гаргадаг байх гэх мэт.

Үүнээс гадна шинийг харуулахад саад болж байгаа хэвшмэл ойлголтуудыг эвдэх, тогтсон хэм хэмжээнээс хальж сэтгэж, боддог байх хэрэгтэй. Тухайн хэлээ сайн эзэмшиж, яруу тод илэрхийлж чаддаг байх нь асар их ач холбогдолтой. Хамгийн гол нь бодит байдлыг тэсч гарч чаддаг байх. Сэтгэл зүйн үүднээс бодит байдал гэж юу вэ, тухайн хүн "үйл явдлын гүнд орох" эсвэл "бүхий л боллоцоогоор зугтахад" юу нөлөөлж байна вэ? Бодит байдал гэдэг бол олон талтай. Энэ нь нэг талаас өөрийг нь онц ноцтой, нөгөө талаас аюултай объект болгодог олон шинж чанарыг хэлнэ.

Хэрэв аюул нь гэнэтийн болон урьдчилан таах аргагүй зүйлтэй холбоотой бол бэрхшээл нь үйл явдал, баримт зэрэг объектив үйл явдал төдийгүй ятган үнэмшүүлэх, дүгнэлт, мэдрэхүй, хэвшмэл ойлголт, сэтгэгдэл зэрэг субъектив үйл явдал агуулсан олон янзын бодит байдлыг хэлнэ (Маслов, Пронина, 1998). Янз бүрийн нөхцөл байдалд зохицон ажиллахын тулд тухайн хүн өнөө үед санаа эсвэл баримт гэх мэт ямар төрлийн бодит байдалтай тулгарч байгаагаа мэдэх нь чухал. Нэгийг нь нөгөөгөөс ялгахад их төвөгтэй, зарим тохиолдолд ялгах ч аргагүй байдаг. Сурвалжлагч гэдэг нь дотоод бодит байдлаас хийсвэрлэн бодит байдалд юу болж байгааг тайлбарладаг хэмээн тодорхойлсон байдаг тул хүмүүс түүнд итгэх хүсэлтэй байдаг.

Төрийн болон хувийн сонин, радио болон телевизийн компаниудын ихэнх мэдээ сурвалжлага зориуд сэтгэл хөдөлсөн, урьдаас тааварласан тодорхойлолт, үүнтэй ижил зохиомол тодорхойлолт, үнэлэлт дүгнэлтээр хүчтэй зэвсэглэсэн нь юуны түрүүнд мэргэжлийн ур чадвар сул, түүнчлэн үзэгч, уншигчид өөрсдийн эрхээ хамгаалах идэвхтэй арга хэрэгсэл байхгүй болохыг харуулж байна. Орчин үеийн үзэгч, сонсогчид өөрийн хараат бус байдлаа өндөр үнэлж, хэрэгтэй мэдээллээ интернетээр хайх чадвартай гэдгийг сануулах нь зүйтэй болов уу.

Сурвалжлагчийн зан чанар ч гэсэн цаг үеэ дагаад өөрчлөгддөг. Сэтгүүлчийн сэтгэхүй дэх дээр хоёр төрлийн бодит байдлын харьцаа ч гэсэн өөрчлөгдөж байгаа. Үйл явдал, эсвэл үзэл санааны "уур амьсгалын" тайлбар зонхилж байна. "Зогсонги жилүүд" нэрээр бичсэн 5-р сарын 1-ний баяр тэмдэглэх сурвалжлагыг аваад үзье. Орчин үеийн ойлголтоор энэ нь сурвалжлага бус шинэ юмны талаар огт дурдаагүй, огт өөрчлөгддөггүй зүйлийг сануулсан "мөнхийн" сэдэв гэж хэлж болох юм. Хатуу дэг жаяг, мэргэ домчдын шийтгэл эсвэл тарнидсан мэт энэ сурвалжлагыг жилээс жилд юуг ч өөрчлөлгүй дахин хэвлэж болно. Дэг жаягаас гажсан ямар нэг юм болсон бол энэ тухай мэдэх боломжгүй юм.

Социалист бүтээн байгуулалтын эрч хүч, хүмүүнлэг байдлыг харуулахын тулд үйлдвэр, сургуулийн нээлтийн сурвалжлага хийдэг байсан. Ийм төрлийн сурвалжлага хэзээ ч бүрмөсөн алга болдоггүй байна. Суртал ухуулга болон сэтгэл зүйн зорилтын агуулга нь чухал бус (цаг хугацаа, газар нутгаас хамаараад янз бүр байж болох) бодит байдлын ойлголтыг хэр хүчтэй тодорхойлж байгаа нь чухал юм.

Эх сурвалж: Зохиолч Е.Е. Пронины "Сурвалжлагчийн уран бүтээлийн ажлын сэтгэл зүйн онцлог" номноос, үргэлжлэл дараагийн дугаарт.

“Өвөөгийн жор” цувралыг дуусгавар болгож “Өвөөгийн бодрол” цуврал эхэлж байна. Бодрол нь монголын уламжлалт бичлэгийн нэгэн сонгомол төрөл зүйл. Хэрэв толь бичиг сөхвөл “БОДРОЛ: Бодрол бичиг 1. Ямар нэг ухааныг тайлбарлах мэдүүлэх зохиол. 2. Хуучирсан хаан эзэнд мэдүүлэх айлтгал бичиг” гэсэн тайлал “Я.Цэвэлийн” гэж алдаршсан том ногоон номны 87 дугаар хуудасны зүүн доод өнцөгт бичсэн байхыг олж унших болно. Харин би бээр тэр сонгодог хэлбэрээр нь бичиж үл чадах тул өөрийнхөө хэмжээнд л эл цувралыг бичнэ. Голоход гомдохгүй. Заримыг нь өөр хүнээр бичүүлнэ.

Соён гэгээрүүлэх чиглэлийн утга зохиол гэдэг түгээмэл утгаар нь авч үзвэл баруунд 16 дугаар зууны үеэс дэлгэрч европын соёлт ард түмэнд ухаалаг амьдрахуйн гүн ухааны сурах бичиг болсоор ирсэн, одоо ч ширээний ном хэвээр байгаа Мишель де Монтений эссэнүүдтэй манай бодрол садан төрлийн сүлбээтэй байж болох юм. Бар, ирээс, шилүүс, мануул, муурыг муурын төрлийн амьтад гэж ангилдагтай адил төсөөллөөр дүйцүүлэх аваас бодрол нь монгол маягийн эссэ ч юмсан уу, сайн хэлж мэдэхгүй байна. Тэгэхдээ энд эссэ бодрол хоёрыг садан төрөл гэж үзэх эсэх нь гол биш.

Миний ойлгож байгаагаар бодрол нь соён гэгээрүүлэх, ухаажуулах чиглэлийн ихэнх бичвэрт байдагчлан сэтгүүл зүй, уран зохиол, гүн ухааны гурвалсан хам шинжтэй байх учиртай гэж бодном. Чингэхлээр бодролд зайлшгүй байж байх ёстой гурван бүтэц нь нэгдүгээрт зохиомол биш бодит амьдрал дээр нэгэнт туршигдсан, үлгэрлэвээс Монтенийн “Туршицууд” шиг үнэн баримтуудтай байх ёстой. Хоёрдугаарт бараг ихэвчлэн шүлгэлэж ярьдаг монголын ард түмний оюун сэтгэлгээний таашаалд нийцэхүйц адилтгал зүйрлэл зураглал, хэл найруулагатай, уран зохиолын төрхтэй байх учиртай. 3. Зөвхөн уншуулж сонирхуулах төдий биш харин сэтгэл оюуныг нь өдөөсөн, шинэ ухаарал, гаргалгааны шижим түлхэц өгөхүй гүн ухаанч байх шаардлагатай.

Энэ удаагийн бодролыг малаараа дэвсгэрлэн бичлээ. Багаасаа малтай ноцолдож өсөөгүй хүмүүст дэндүү хоцрогдсон санагдаж магадгүй тул хүлцэхийг хусье.

Соёлын гавъяат зүтгэлтэн Хорлоогийн ЦЭВЛЭЭ

БОРЛОГ ҮРЭЭ

-бодрол-

Хэрэв монгол мал байхгүй байсан бол? гэсэн асуулт миний бодол санааг яг л асуултын тэмдэг шиг махилгаж байна. Лам багшийг хүн бүр хүндэлдэг. Лам гэсэн үгийг тонгоруулаад бичвэл мал гэсэн үг болно. Тиймээ, мал багш. Энэ бол лам багш маань мал шиг тэнэг гэсэн үг биш. Харин мал маань бидэнд лам багш шиг ертөнцийн гэгээн ухаарлаар оюуны адис тавьж байдаг гэсэн санаа. Үнэмшмээргүй боловч үнэмшүүлэх гээд үзье.

Жишээ нь, хэрэв морь туурайтай биш дугуйтай байсан бол монголчууд найман цагаантай, нанжин гахай гөлөмтэй боржигон эмээл гэдэг ур ухааны эрхэм дээд бүтээлийг урлан бүтээх нь байтугай ерөөс морины эмээл гэдэг нэгэн сонин зүй тогтол хорвоогийн бодит ахуйд оршин байдгийг таниж мэдэхгүй л өнгөрөх байсан.

Хэрэв морьд айлын таньдаг нохой шиг өөрөө шарваганаад хүрээд ирдэг байсан бол монгол хүн морь уургалах гайхамшигийг нээн эзэмшиж чадахгүй байсан. Тэгэхлээр найман алдын хусан уурга, оонын хүзүүгээр гурамсалж сүлжсэн хуйв гэдэг хүмүүн төрөлхтний ахуйн хэрэглээний маш тансаг гоё үнэт эд зүйлс байж болох байсныг хүмүүн төрөлхтний түүх танин мэдэхгүй дараачийнхаа эрин галавт халаагаа өгч дуусах байсан биз ээ. Энэчлэн мал маань эсгий гэр, хивсэн дохош, буйл бурантаг, үхэр тэрэг, гэр тэрэг, айргийн хөхүүр, араг шээзгий гээд их олон зүйлд монголчуудыг сургажээ. Мал багшийн тухай хийсвэр сэтгэмжийг үүгээр цэглэж тов тодорхой баримт жишээ рүү ойртоё.

1952 оны хавар юмсан. Адуу дэллэж хөөвөрлүүлэхээр бидний гурван залуу Баянхонгорын Бөмбөгөр сумын нэгдүгээр багт томилогдон очлоо. Тэр үед багаасаа малтай ноцолдож өссөн сумын албан хаагч залууст адуу дэллүүлэх шиг хийморлог сайхан ажил байгаагүй байх. Эмнэг хангал адуутай ноцолдох, уургалах, бугуйлдах... Хэрдээ л эр улсын нэгэн их ид хав болдогсон. Би хувьдаа даага шүдлэн зэрэг бага насны адууг дэлдэж гүйлгээд ачиж унагах дуртай байсан. Баавгай барьж аваад унагачихсан юм шиг хөөрцөглөдөг байж билээ. Баасанбат маань морь уургалах дуртай. Зэгвийн Даржаа эмнэг адуу зайдан унаж булгиулахдаа чухам л нар нь гардагсан.

Нэг өдөр Сандарын Ойдов гуай Ангархайн ам орчим бараг хангал зэлүүд яваа адуугаа тууж ирж дэлүүлэх юм боллоо. Ээ хөөрхий, маргааш өглөө нь Ойдов гуай яг л хулан дахь шиг хул хонгор адуунуудаа Өлзийт голын Өлийн амны доод шанаагаад өгсүүлээд ирж яваа харагдана. Дэл нь сэглийдээд одоогоор бол африкийн эр арслангууд шиг,

тэгснээ биднийг ойртож очихын бараанаар хамар нь тачигнаад зарим нь сүүл толгой нийлүүлэн цойлоод сүртэй ч гэж жигтэйхэн. Хүйтэн амны Шар чулууны адууны хороонд хашаад авлаа. Гарт орлоо доо хөөрхий адгуус.

Хул хонгор голдуу зүсний гучаад адууны дотор нэг тарган борлог үрээ тогтож ядан толгойгоо хулан шиг дээш өргөөд хамраа сарталзуулан хуухчиг давхиад хавьтахын аргагүй аашилж байлаа. Шүдлэнд нь сургах гээд дийлээгүй юм гэнэ. Баасанбат маань хөөрхөн барилдана, цэргээс ирээд өнгөрсөн наадмаар сумын начин цол авсан, бидэнд дотроо чухам л бяр амтагдсан нэгэн явлаа. Сумын өртөөнөөс түүний унаанд өгсөн морь нь нэлээн сульдаж явсныг ч хэлэх үү, тэр борлог үрээг хараад унахсан хэмээн хорхойссон янзтай борлог үрээг чинь худалдан авъя гэж эзнээс нь гуйлаа. Сургаж дийлэх юм бол ав ав гээд Ойдов гуай инээвхийлж байна. Ер нь дандаан инээж явдаг учраас “Инээдэг” гэж дууддаг байсан юм нутгийнхан.

Мөнөөх хангал борлог үрээг эмээлээд авлаа. Юмыг яаж мэдэхэв гээд татлагын сураар урт цулбуур хийж нэг нь биариад Баасанбат маань мордлоо. Борлог үрээ ороилоод л, урд хөлнийхөө хооронд толгойгоо хийгээд зэрүүлэн дугуй шиг эргэн цамнан тонгочиж эхлэлээ. Нэлээн тэслээ. Гэвч нэг эргэлтэн дээр нь хийсээд явчихлаа. Дараа нь Даржаа маань уналаа. Бас л тогтсонгүй. Довчин, Содном, Лхагважав гээд нутгийн залуус ч нуруун дээр нь тогтсонгүй шороон дээр тавиуллаа. Олон залуус сэлгэж унасны хүчээр сүүлдээ бага зэрэг цуцах янзтай байсан ч дийлдэхгүй байж билээ. Сүүлдээ ярдаглаж хэвтчихээд босдоггүй шүү. Тэгсхийгээд орхисонсон.

Дараа нь агт бэлтгэл болоход борлог үрээг хамгийн түрүүнд агтанд туусан сураг гарсан. Тэгээд л Мааньтын өртөөнөөс вагонд ачигдаад Орос руу очиж мөнөөх гуурст хөлөг шиг сэргэлэн сэхүүн явсан эрхэмсэг онгон амьдрал нь дууссан байлгүй дээ. Тэр нэгэн бодлын тэнэг амьтан. Хүмүүн бидэн шиг шударга биш амьтан байсан бол агтанд туулгах аюулаас амиа аргалаад гарчих байсан гэж боддог. Гэхдээ борлог үрээ хүмүүсийг албан тушаал, алдар нэрээр нь ялгаварлаж, алаг үзэж тал тохой татахыг мэддэггүй шулуун шударга амьтан байсан учраас л нарт хорвоог эрт орхих болсон доо, хөөрхий минь.

Борлог үрээ бас гавъяатай нэгэн байсан. Яагаад гэвэл би түүнийг тавин хэдэн жил мартажгүй явсаар нийтийн хэвлэлд одоо бичиж үлдээлээ. Богинохон насалсан боловч богино гэж чамламгүй сургажтай амьд явжээ. Бүхэнд нэгэн янзаар хандаж байснаараа тэгш шударгын үлгэр жишээг

үзүүлсэн боловч бас унааны морь байх заяамал үүргээс зайлсхийж дэндүү ааш муутай байсны харгагайгаар “Хариуцлага алдаж” агтанд туугдсан тэр хөөрхий адгуус алдарт А.С.Пушкин, Дашдоржийн Нацагдорж тэргүүтэн шиг үхсэн хойноо ч миний сэтгэл оюуныг өөрийн хэр чинээгээр тэжээж байгааг би мэдэрч бусад хүний оюуны нэгэн шим болоосой гэсэндээ өөрийнхөө мэддэг цөөн үгээр өртөөлөн дамжуулж сууна.

Бас нэгэн сургамжтай баримт надад хадгалагдсаар эдүгээ хагас зуун жилийн босгыг давжээ. Тавиад оны эхээр юмсан. Бид хорин нас хүрч цэргийн зарлан дуудах авлаа. Аймгийн төв дээр очиж цэрэг татлагын комисст үзүүлэхээр мордоцгоолоо. Аймгийн төв маань тэр үед Баянхонгор хайрхан уулын өвөрт одоогийн Галуут сумын төв байгаагийн тэнд байсан. Манай сум гуравхан өртөө зайтай л даа, аймгийн төвөөс. Би хүргэн ах Чойдогийнхоос соёолон насны шоо шиг дөрвөлжин хэвтэй, тосон хүрэн зүстэй морийг нь гуйж унаад явсан юм. Комисст ороод чөлөөлөгдлөө. Тэр үед эвлэлийн үүрийн дарга нарыг цэргээс чөлөөлдөг байсан юм.

Нар шингэхэд л бид комисслуулж дууссан тул манай багаас очсон хэсэг залуус аймаг дээр байдаг нутгийн таньдаг айлд хонолоо. Морьдоо чөдөрлөж тавьцгаав. Өглөө боссон чинь чөдөртэй морьдын бараа харагдсангүй. Чөдөр ногтны хулгайч нар морьдыг суллаад тавьчихаж. Ихэнх нь дөнгөж адуунаас барьсан цатгалан морьд өвс ногоонд хоргодохгүй шөнөдөө л хүрэх газраа хүрээ биз. Явгарчихлаа. Яаж унаажина даа гээд гайхширч байтал аймгийн төвийн баруун асганы дундаас ганц бараан адуу цухуйлаа. Сайн харсан чинь миний хүрэн морь ганцаараа зогсож байна. Баярласан гэдэг нь. Хүрээд очиход хошуугаа над руу хандуулаад үнэрлэсэн гээч.

Сув сул болсон ч хүний газар намайг явгалаагүй хүлээгээд зогсож байсан тийм сайхан амьтныг чинь өөрийн унаа болгохыг хүсэхгүй яаж тэснэм. Чойдог ахаас гуйж байгаад худалдаж авсан. 3 жилийн дараа би сумаас аймаг шилжиж улмаар хотын хүн болсон боловч хүрэн морио зарж үрээгүй дүүгийнхээ үлдээсэн. Надад ирээд “Цэвлээгийн хүрэн” нэртэй 27 жил болсондоо. 32 нас хүрээд зөөртөө үхсэн гэсэн. Толгойг нь нутгийн нэг уулын орой дээр залсан гэж талийгч дүү маань ярьж байсан. Түүнээс хойш гучаад жил өнгөрч байна.

Бодоход адуу байх, морь байх, хүлэг байх нь гурван өөр өгөгдөхүүн юм уу даа. Миний хүрэн морь бол хүний нутаг, гүний хошуунд эзнээ явгалаагүй үнэнч хүлэг байсан. Өөрийн оноолттой сайн хүлэгтээ эзнийх нь сэтгэл уусан шингэдэг учиртай биз. Би хүрэн морио өөрөөс мартдаггүй. Миний хүрэн морь шиг жудагтай үнэнч байдагсан бол хүн төрөлхтөн түүний дотор монголчууд өнөөдөр мөн ч налгар сайхнаар амар жимэр амьдарцгаах байсан даа.

Үнэнч шударга ёс гэдгийг хүмүүс бид хүний бодит амьдрал ахуйгаас эрээд тэр бүр олж чадахгүй байна. Түүний оронд үнэнч шударга байхын үлгэр жишээг бэлчээрт явдаг мал сүргээсээ олж хараад түүнээсээ ухаажиг суралцвал арай ойр дөт юм биш үү. Адуу мал шиг үнэнч шударга ааш араншинтай байцгаая, та минь гэж уншигчдыг уриалахсан. Гэтэл долдой байхыг хүсэгчид манайд илүү олон байгаа болохоор ард түмнийг мал мэт тэнэг байлгахыг социализмын үеийн зөнөг бичээч уриалсан гээд гуйвуулчих болов уу. Баттай эх сурвалжийн мэдээгээр таван мянган жилийн тэртээгээс мал сүргээ гаршуулан адуулж ирсэн монгол түмэн өнөөдөр малаасаа долоон дор ааш араншинтай байхдаа ч яахав дээ.

Хэрэв адуу мал нь хүний хэлээр ярьдаг байсан бол санасан санаагаа үг яриагаараа өнгөлөн далдалж яриад түүндээ дасчихсан бидний зүрх дэлбэрч ч мэднэ. Өнөөдрийнх шиг амьдарч байгааг бодохоор халуун бүтэц дотор нь монголчууд бидний унаж босч, дээшилж доошилж, үхэж төрж яваа эдүгээ цагийн монгол амьдрал гэдэг чинь жинхэнэ бодит үнэн амьдрал гэхээсээ хэн нэгний зохиосон кино жүжиг юм шиг ээ. Цаг үргэлж л кино жүжигт гардаг шиг нэг нь нөгөөгөө хохироож тунч их хорлонтой амьдардаг

болчихож. Тэглээ гээд тооцох хариуцлага их суларч. Монголчууд чинь албаны хүмүүст байтугай ачлаганы малдаа хүртэл хатуу хариуцлага оноодог няхуур уламжлалтай улс юмсан.

Сонин баримт санаад орж байна л даа. Баримжаагаар тоолоход 1910-аад оны үед шиг байгаа юм. Нилх Бандь гэдэг цөлх хашир өвгөнийх Ямбатын өврийн Шар цохионы өвөлжөө гэдгээс Өлзийт голын захад хаваржаалахаар хэдэн үхэрээ нуруу ачаалаад нүүжээ. Утиартын богочны уруу тонгойсон даруй бух болгохоор үлдээсэн хүрэн гунаны шалангийн татуурга (монгол үхэр бөгтөр нуруутай учраас ачаа нь толгой руугаа гүйхээс сэргийлж сүүлний нь доогуур оруулж татдаг татлагыг шалан гэдэг байсан юм) тас үсрээд ачаа нь чээж рүүгээ ороод ирж. Тэгтэл нэг адсага унаатахаж. Гуна үргээд зайлтал зарим ачаа нь нураад ойчиж. Гунаан бух тонгожиж гарч. Ачаанууд нь савираад цацагдчихаж. Нэг ширмэн тогоо тээр тэнд дунгуйлдаад явчихаж гэнэ. Түүнийг харсан нилх Бандь гуай аман дотроо “Хэрвээ тогоо хагалсан байвал чамайг тэгнэ, тогоо хагалаагүй байвал тэгнэ” гэж бусдад сонсогдтол бувтнаж явж. Тогоо нь ч хагараагүй бүтэн байж. Буух газраа хүрчээ. Ачаагаа буулгасны дараа гэрээ ч бариагүй байж “Алийв чи энэ үзүүрээс тат” гэж дүү Аюушдаа мөнөөх гунын зүүн урд хөлнөөс уясан сурны үзүүрийг бариулж өөрөө нөгөө хөлийг давхар оосорлож аван угз татаад бухаа унагаад авч. Тэгээд хүлснийхээ дараа бүсэн дэх эвэр иштэй том хутгаа хуйнаас нь сугалаад ирвэ гэнэ. Тэгтэл дүү нь “Үгүй та чинь яаж байгаа юм бэ? Бухаа алах нь үү?” гээд орилж гэнэ. Бандь гуай үг ч дуугарсангүй шуудхан очоод өнөөх хөөрхөн хүрэн бухныхаа хуухнагийн зүсээд хоёр бандууг нь суга татаад хаячиж гэнэ. Сайхь хүрэн гуна тэр айлын хэдэн үнээний бух байх бүрэн эрхээ хасуулсан нэгэн түүх энэ ээ.

Хэрэв тэр гуна мөнөөх эзэн айлынхаа үнэ цэнэтэй эд юмсыг ачиж яваагаа ухаардаг, эзнийхээ итгэлийг алдвал засагаа сугалуулна гэдгийг мэддэг байсан бол бух байх хайран сайхан эрх мэдлээс салах тийм гэм буруу үйлдэл хийхгүй байсан биз. Хэл мэдэхгүй тэр адгуусыг нэг удаа уучилж болох л байсан. Гэвч цөлх ухаантайдаа “Нилх” хэмээн хочлогддог байсан Дуламын Бандь агсан түүнийг бага залуу юм гэж уучлахыг хүсээгүй, хариуцлагыг төр дор нь яг яс тооцсон байдгийм.

Сайхь гуна шиг ачаагаа туйлж хаядаг ааш муутай гунаар бух тавих аваас үр төл нь бас л ааштай догшин байна гэж хаширласан учраас тийн шийдсэн хэрэг. Малчны сонжих ухаан их нарийн байж дээ. Харин өнөөгийн бид эцэг малыг байтугай төрийн түшээ болох улс төрчдийнхөө ааш араншинг нь нягтлан сонжихгүй байгаа нь цаашдаа ааширхаг догшин засаг төр гараад ирэхийг байг гэхгүй.

Төр нийгмийн үнэтэй цэнэтэй баялгийг үрэн таран хийсэн улс төр, засаг захиргааны ажилтнуудад хатуу хариуцлага тооцож, “Гунаан бух шиг урамдаад ирэхэд нь гунжин үнээ шиг гунганаж угтчихаад” алтан сүүгээр саамширч байдаг албан сэнтийгээс нь өлчир малчин Бандь гуай гунаан бухныхаа засаг шууд л суга татчихсан шиг аваад хаячихдагсан бол төр төллөж, улс ургах урин дулаан цаг холгүй ойрхон л байна даа. Даанч “Далдын хар малгайнууд” (авилга) хариуцлагын тогтолцоог сүүдэрлэхчээд болж өгөхгүй юм.

Харин мөнөөх тогоогий нь хагалсан байсан бол яах байсныг Бандь гуай дараа нь тайлж хэлээгүй, бусад нь ч асуугаагүй өнгөрсөн гэсэн. Бодвоос бусдад худалдаж далд оруулах байсан болов уу. Монголчууд эцэг малаа алж иддэг ёс байдаггүй юм чинь зарахаас өөрөөр яав л гэж. Өнөөдрийн бидэн шиг хулгайгаар нядалж зах дээр зарж байгаа хөгшин буур азарга, бух, хуц, ухнын махаар хийсэн заартай бууз хуушуурыг хавагнатлаа иддэггүй байсан цаг юм даа.

Үнэнч жудаг, шударга ёс, үүрэг хариуцлагын тухай малын ааш араншингаас ухаарсан сургамжийг ийнхүү хичээнгүйлэн толилуулав аа. Мал малчин хоёроос сурах юм их байна шүү.

АВИЛГАТАЙ ТЭМЦЭХЭД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ОРОЛЦОО

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 2003 оны 10 сарын 31-нд Авилгалын эсрэг конвенцийг баталж, Монгол Улс 2005 оны 10 сарын 27-ны өдөр соёрхон баталжээ. Одоогийн байдлаар Монгол Улс Авилгалын эсрэг хууль батлан гаргасан, Авилгалтай тэмцэх байгууллага байгуулсан зэрэг нь уг конвенцоор хүлээсэн үүргийнхээ заримыг биелүүлж эхлээд байна гэсэн үг. Гэхдээ авилгалтай тэмцэх байгууллагатай болсноороо авилгыг огт байхгүй болгоно гэдэг бол эргэлзээтэй.

Өөрөөр хэлбэл, авилгатай нийгмээрээ бүхэлдээ хамтран тэмцэж байж сая тодорхой үр дүнд хүрнэ гэсэн үг. Үүнд сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг маш өндөр. Авилгатай тэмцэхийн тулд сэтгүүлчид нийт ард иргэдийг соён гэгээрүүлэх, авилгалыг үл тэвчих сэтгэлзүйг нийгэмд төлөвшүүлэх, авилгын тухай мэдээ баримтыг эрэн сурвалжилж нийтэд дэлгэн тавьж авилгаас жигшүүлэн нийгмийг цэвэршүүлэх үйл хэрэгт оролцож иргэдийн дуу хоолой, харах нүд, сонсох чих болж байх нь маш чухал юм.

Ер нь авилга гэх үгээр тодорхойлогдох үйлдэл нь маш өргөн хүрээ, олон төрөл хэлбэртэй бөгөөд маш ноцтой хор уршигтай гэмт хэрэг мөн гэдгийг дэлхий нийтээрээ нэгэн дуугаар хүлээн зөвшөөрчээ. Гэхдээ манай улсад үйлчилж байгаа Эрүүгийн хуульд авилгыг ерөнхийд нь хээл хахууль хэмээн тодорхойлсон байдаг. Өнөөдөр манай нийгэмд тогтсон нэгэн эмгэнэлтэй дүр зураг бол хээл хахуулийн гэмт хэргийн хохирогч гэж хэн бэ гэдгийг бүрэн гүйцэд ойлгохгүй байгаа нь ажиглагддаг. Өөрөөр хэлбэл орчин цагт хэвлэл мэдээллийн ихэнх хэрэгслээр түгээмэл ярьдаг нэгэн алдаатай зүйл бол “авсан өгсөн хоёр хоёулаа сэтгэл хангалуун үлддэг” гэх утгатай мэдээлэл юм. Энд байгаа гол алдаа нь юу вэ гэвэл авилга авч байгаа нь гэмт хэрэг үйлдэж байна, авилга өгч байгаа нь гэмт хэргийн хохирогч болж гэх сэтгэгдэл төрүүлэхүйц байна. Гэтэл жинхэнэ ёсоороо бол аль аль гэмт хэрэгтэн болж байгаа юм. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 268-р зүйлд “Хээл хахууль авах”, 269-р зүйлд “Хээл хахууль өгөх” гэмт хэргүүдийг үйлдлээр нь ялган тус тусад нь гэмт хэрэг мөн гэж үзжээ. Түүнчлэн дээрх хоёроос гадна тухайн гэмт хэрэгт зуучилсан үйлдэл нь хүртэл гэмт хэрэг болохыг Эрүүгийн хуулийн 270-р зүйлээр “Хээл хахууль зуучлах” гэж тодорхойлсон. Мөн дээрх гурван хэлбэрээс гадна албан тушаалын гэмт хэргийн шинжгүй бол 170 дугаар зүйлд **Хууль бусаар шан харамж авах**-ыг мөн л гэмт хэрэг хэмээн тодорхойлжээ.

Тэгэхээр энэ гэмт хэргийн хохирогч хэн бэ гэдгийг хамгийн товчхоноор хэлбэл “**ТА**” өөрөө. Та гэдгийг бага зэрэг тайлбарлахад сэтгүүлч та болон нийгмийн харилцаанд оролцож байгаа бусад жирийн иргэд бүгдээрээ гэж ойлгож болно. Яагаад бид бүгдээрээ хохирогч болоод байгаад дараах жишээгээр тайлбарлахыг оролдоё. Та ямар нэгэн тендерт шалгарахаар хэн нэгэнтэй өрсөлдөж байжээ. Гэтэл таны өрсөлдөгч тендерт хэнийг шалгаруулахыг шийдэх онцгой эрхтэй этгээдэд авилга өгснөөр таны тендерт шалгарах байсан боломжийг нухчин дарж таныг хохироож байна. Хамгийн наад зах нь тендерт оролцож ялахын тулд та багагүй хөрөнгө зардал, цаг хугацаа зарцуулах нь тодорхой. Та тэрхүү гаргасан зардал хөрөнгө, хугацаагаараа хохирч байна. Мөн тухайн тендерт та болон авилга өгсөн

гэмт этгээд хоёулхнаа өрсөлдөхгүй өөр маш олон субъектүүд өрсөлдөх нь ойлгомжтой. Түүнчлэн тухайн өрсөлдөгч нараас гадна танай бараа бүтээгдэхүүний хэрэглэгчид хууль бусаар тендерт шалгарсан этгээдийн чанаргүй бүтээгдэхүүнийг хэрэглэснээрээ мөн хохирогч болж байна. Иймээс та энэ хэргийн хохирогч ганцаараа биш гэдэг нь харагдаж байна. Тэгээд дээрх жишээ авсан тендер шалгаруулахтай холбоотой авилгаас гадна бусад салбарт байдаг авилгатай нийлүүлэн бодвол маш өргөн хүрээтэй асар их хор уршиг, сөрөг үр дагавартай юм.

Энэ гэмт хэргийн хохирогч авилгын гэмт хэрэг үйлдэгдсэн гэдгийг ихэнхи тохиолдолд мэдэх боломжгүй байдаг тул энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэн шүүхээс ял шийтгэх нь байтугай, үйлдэгдсэн тухай мэдээлэл нь хүртэл олддоггүй. Тиймээс авилгатай тэмцэхэд хамгийн чухал зүйл нь энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдал юм.

Авилгад өртөмтгий байж болох төрийн албан тушаалтнуудыг авилга авах явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд тэдний хөрөнгө, орлогын мэдүүлгийг нээлттэй ил тод байлгах, түүнчлэн тухайн төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зэрэг нь нэн чухал юм. Түүнээс гадна авилгад өртөмтгий хэсгийн хөрөнгө орлогын мэдүүлэгт хяналт тавьж, олсон орлогоо хаанаас бий болгосноо нотлох баримттайгаар тайлбарлаж чадахгүй бол үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хэмээн үзэж, хээл хахууль авах гэмт хэрэгт сэжигтнээр татагдан шалгагдах ёстой мэт.

Энэ нь Олон Улсын Сэтгүүлчдийн холбооноос 1954 онд батлан гаргасан Сэтгүүлчдийн Баримтлах Зарчмын 3-р зүйлд “...Сэтгүүлч чухал мэдээ

нуун дарах юм уу баримт сэлтийг мушгин гуйвуулж болохгүй” гэж заасан байдаг. Үүнд заасан чухал мэдээ гэдгийг хэрхэн ойлгох вэ гэвэл хэдийгээр олон талтай ойлголт ч гэсэн хамгийн гол нь хууль бус, хэн нэгний эрх ашгийг ноцтойгоор хохироосон үйлдэл, үйл явдлыг хэвлэлийн хуудсанд дэлгэн тавихгүй байх нь сэтгүүлч та мэргэжлийн ёс зүйн дүрмээ зөрчиж, нийгмийн өмнө хүлээсэн үүргээсээ ухарсан явдал болох юм.

Өөрөөр хэлбэл, ардчилсан нийгэм дэх хэвлэл мэдээллийн үүрэг бол нийгмийн хоточ нохой байх явдлаар тодорхойлогдоно. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь тухайн нийгэмд байгаа шударга бус явдлын тухай байнга шүүмжилж байснаар сая нийгэм эрүүлжинэ.

Мөн хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрөө авилга авах явдал байж болохгүй. ОУСХ-ны Сэтгүүлчдийн Баримтлах Зарчмын 8-р зүйлд “**Дараах зүйлийг сэтгүүлч мэргэжлийн ноцтой алдаанд тооцно: ...Юмыг нийтэд мэдээлэх эсэхийг шийдэхдээ ямарваа нэг хэлбэрээр хээл хахууль авах**” гэжээ. Хэрвээ дээрх заалтыг сэтгүүлч зөрчвөл нийгмийн “хоточ нохой” бус харин урдаг нохой болж хувирах аюултай. Үүний үр дүн нь юу вэ гэвэл тухайн нийгэм ардчилсан гэх тодотголтой байж яагаад чадахгүйд хүрнэ. Өөрөөр хэлбэл, хараат бус хэвлэл мэдээлэл нь ардчилсан нийгмийн амин сүнс хөдөлгөгч хүч нь юм.

Хуульч Г.Даваахүү

Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхын аргаар, эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана. /Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пакт, 19 дүгээр зүйл/

Тэд асууж байна

Хүний дархлал хомсдлын вирусийн (ХДХВ) талаар мэдээлэх гэдэг нь бүх сэтгүүл зүйн нэгэн адил тухайн улс оронд болж байгаа үйл явдлын тусгал бөгөөд энэ нь өвчин дамжих (халдварлах), уг өвчнөөс урьдчилан сэргийлэх болон эмчлэх талаарх хүмүүсийн төөрөгдөл, бусдыг буруутган зэмлэх хүмүүсийн эрмэлзлэлээс үүдэн бодит байдлыг гуйвуулан хувиргаж болзошгүй байдаг. Тиймээс баримтыг худал хуурмаг зүйлээс ялгаж салгах нь чухал. Хүний дархлал олдмол хомсдол нь цус болон цусан бүтээгдэхүүнээр, эхээс хүүхдэд дамжин, мансууруулах бодис тарихад болон бэлгийн замаар халдварладаг болохыг бид мэднэ. Мөн ХДХВ нь агаар дуслуар халддаггүй, шатны бариул, жорлонгийн суултуур тэрчлэн олон нийтийн бусад газар амьдрах чадваргүй болохыг ч бас мэднэ.

СЭТГҮҮЛЧДИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

ХДХВ нь зөвхөн эрүүл мэндээр хязгаарлагдахгүй бизнес, хөгжил болон аюулгүй байдлын асуудал юм. Хэвлэл мэдээллийг дэмжих чиглэлээр ажилладаг Интерньюс байгууллагад Энэтхэгийн нэгэн мэргэжилтний үүнтэй холбоотой юу ярьсныг сийрүүлье: “(итгэлтэй) сэтгүүлч аль ч салбараар мэргэшсэн бай, ХДХВ/ДОХ-ын асуудалтай тулгарахгүй байж чадах уу гэсэн асуулт өнөө үед гарч байна. ДОХ өвчин нь зөвхөн эрүүл мэндтэй холбоотой асуудал биш юм. Энэ нь нийгмийн үйлчилгээ, улс төр, бизнес, хөгжлийн асуудалд нөлөөлнө. Жендерийн тэгш бус харилцаа, ядуурлыг бууруулах хөтөлбөр, таван жилийн төлөвлөгөө, орлого бүрдүүлэх хөтөлбөр зэрэгт дүн шинжилгээ хийж чаддаг сэтгүүлчийн хувьд энэ нь дангаараа олон асуудлыг араасаа дагалдуулдаг зүйл юм. Гадаад харилцаагаар мэргэшсэн сэтгүүлч Энэтхэгт үзүүлж буй олон улсын тусламжийн талаар дүн шинжилгээ хийж, тус улсад үзүүлж буй тусламжийн ард олон улсын ямар бодлого явж байгаа талаар үнэн мөнийг олж болох юм. Бизнесийн чиглэлээр мэргэшсэн сэтгүүлч вирусийн эсрэг эмийн талаар, мөн патентын асуудлыг нягтлаж болно. Харамсалтай нь ийм байдал төдийлөн харагдахгүй байна.”

Эх сурвалж: Интерньюс, www.internews.org, Интерньюсийн техникийн эрүүл мэндийн зөвлөх доктор Жая Шридар.

СОРИЛТ, АСУУЛТ БОЛОН БУСАД ЗҮЙЛ

ХДХВ болон халдвар авах, түүнээс урьдчилан сэргийлэх талаар үнэн зөв мэдээлэл түгээхэд засгийн газрууд, сүм хийд, шашны байгууллагууд голчлон хамгийн том саад тотгор болдог.

Хэрэв та мэдээ, нийтлэлээ түгээхэд ямар нэг саад бэрхшээлтэй тулгарвал саад тотгор хаана байгааг эргэцүүл. Засгийн газар танай орон дахь ХДХВ-ийн талаар алдаа мадаггүй нарийвчилсан баримтуудыг түгээж байна уу? Засгийн газар тань ХДХВ/ДОХ өвчлөлийн түвшиний талаар статистик тоо баримт гаргаж байна уу? Хэрэв та статистик тоо баримт олж чадахгүй байгаа бол, хэрэв та ямар нэг зүйлийг хэмжиж чадахгүй бол өөрчилж чадахгүй, тэгэхлээр асуулт тавьж эхлэх цаг иржээ.

ХҮНД АСУУЛТ ТАВЬЖ, ЗАСГИЙН ГАЗРАА СОРЬ

- Засгийн газар ХДХВ тархахаас сэргийлэх ямар арга хэмжээ авч байна вэ? ХДХВ-ээр халдварласан хүмүүст хэрхэн тусалж байна вэ?
- ДОХ болон ХДХВ-тэй хүмүүст ретровирусийн эмчилгээ хийх, халдварын эсрэг эмээр хангах хөтөлбөр Засгийн газарт байна уу?
- ХДХВ-ийн үндэсний стратеги боловсруулахад эрдэмтэн судлаач, доктор болон нийгмийн бүлгүүдийн зэрэгцээ ХДХВ-тэй хүмүүсийг оролцуулсан уу? Ер нь ийм стратеги Засгийн газарт байна уу?
- ХДХВ-ын эсрэг Засгийн газар хэдий хэр хэмжээний мөнгө зарцуулсан бэ? Ихэвчлэн ХДХВ-ийн угтвар болдог бэлгийн замын халдварт өвчний талаар засгийн газар ямар арга хэмжээ авч байна вэ?

- Хүмүүсийн бэлгийн амьдралд бодитоор тусдаг аюулгүй сексийг хөхиүлэн дэмжсэн аян болон бэлгэвчийн хэрэглээг Засгийн газар дэмжиж байна уу?

ШАШИНГ СОРИХУЙ

Манай нийгэмд шашин нөлөө бүхий, том үүрэг гүйцэтгэдэг. Шашны зүгээс ХДХВ/ДОХ-ын талаар ямар байр суурьтай байна вэ?

Сүм хийдүүд зөвхөн цээрлэсэн хөтөлбөрийг дэмжиж байна уу? Хэрэв тийм бол шинжлэх ухааны ямар үндэслэлээр үүнийг дэмжиж байна вэ? Цээрлэсэн хөтөлбөрийн үр дүнд ХДХВ болон бэлгийн замын бусад халдварт өвчтэй хүмүүсийн тоо буурч байгаа талаар тухайн сүм хийд баттай статистик тоо баримт гаргаж өгч чадах уу? Хэрэв ийм тоо баримт гаргаж өгч чадахгүй байгаа бол сүм хийдүүд ХДХВ-ийн эсрэг бодит үр дүнтэй халдвартай хүмүүст энэрэн туслах үүргээсээ няцаж байна уу?

Тухайн сүм хийд сүсэгтнүүдтэйгээ ХДХВ-ийн талаар ярилцдаг уу? Тэд цээрлэхийг номлохоос гадна ХДХВ-ээс хэрхэн сэргийлэх талаар сүсэгтнүүдтэйгээ ярьдаг уу? Хамгийн гол нь тэд бэлгэвчийн талаар ярилцдаг уу?

МЭДЭЭ, СТАТИСТИК ТОО БАРИМТЫГ УНШИЖ СУРАХ

Зарим нэг орон ХДХВ-ийн тохиолдлыг нийт хүн амын судалгаа болох тахал судлалын нэр томъёогоор илэрхийлдэг тул статистик тоо баримт, мэдээллийг энэ судалгаагаар боловсруулдаг байна.

Тохиолдол их хэмжээгээр нэмэгдсэн эсвэл буурсан мэт санагдах ХДХВ-ийн тоо баримт нь хэрэг дээрээ цөөн тооны тохиолдлыг хэлсэн байж болно. Жишээ нь: ХДХВ-ийн тохиолдол 14 хувиар нэмэгдсэн гэдэг нь халдвартай хүмүүсийн тоо эрс нэмэгдсэн мэт санагдах авч, энэ нь ердөө 12 тохиолдол нэмэгдсэнийг илтгэж болно.

ХДХВ-тэй холбоотой төөрөгдөлд оруулж болзошгүй өөр нэг ойлголт нь аль улсыг хэмжиж байгаагаас шалтгаалсан тухайн улсад зонхилох түвшин буюу ХДХВ-ийн халдвар авсан хүн амын хувь юм.

Жишээ нь: Энэтхэгт зонхилох түвшин нь хүн амын 2 хувиас доогуур байна гэдэг нь хүн амын тооноос хамаарах учир ХДХВ-ийн халдварын зонхилох түвшин нь насны тодорхой бүлгүүдэд голчлон 20 орчим хувь байдаг Африкийн олон орныхоос их байгааг илтгэнэ.



Customer Realition Management /CRM/ буюу хэрэглэгчийн харилцааны менежментийг мянганы маркетингийн хамгийн хүчтэй зэвсэг гэж тодорхойлжээ. Энэ нь хэвлэн нийтлэгчдэд ямар ашиг тустай вэ? Ямар саад тотгороос зайлсхийх ёстой вэ? Мэдээний редакцийн шинэхэн захиалагчаас өгсүүлээд сонины газар шат шатаар хэрэгжүүлэх удирдамжийг энд өгүүлнэ.

ХЭРЭГЛЭГЧТЭЙ ХАРИЛЦАХ МЕНЕЖМЕНТ ГЭЖ ЮУ ВЭ?

Хэрэглэгчийн харилцааны менежмент гэдэг нь олон хүнийг хэрэглэгчээ болгохыг хүсдэг, хэрэглэгчдийн тоог хэвээр хадгалах эрмэлзэлтэй, хамтарч ажиллахад сэтгэл хангалуун байх тийм харилцаа тогтоохыг хэлнэ.

CRM нь хүний аливаа харилцааны адилаар бүхэлдээ харилцан ойлголцлыг хэлнэ. Хүмүүсийг сайн ойлгосноор, Тэд хэн юм бэ? Тэдний хэрэгцээ юу вэ? Тэд юуг шүүмжилдэг вэ? Бид юуг сайн хийж чадна гэж тэд боддог вэ? зэрэг асуултад хариулснаар тэдний итгэлийг хүлээж чадна.

Сонины тухайд энэ үйл явцын үнэ цэнэ маш чухал ач холбогдолтой юм. Бид хоёр төрлийн хэрэглэгчийн хэрэгцээг хангах хэрэгтэй байдаг:

Уншигч - өөрт нь хамгийн их хамаатай, сэтгэлд нийцсэн агуулгыг хамгийн хүртээмжтэй хэлбэрээр хүлээж авахаар эрж хайж байгаа хүмүүс,

Сурталчлуулагч - тусгай хэсэг бүлэг хүнд мэдээллээ хүргэх хүсэлтэй хүмүүс

Бид уншигчидтайгаа сайн харилцаа бэхжүүлэх тусам сурталчлуулагч, уншигч хоёрыг улам нягтруулж чадна.

Сонины хэвлэн нийтлэгч уншигчидтайгаа урьд өмнөхөөс илүү дотно холбоо тогтоох шаардлагатай хоёр шалтгаан байна. Үүнд:

1. Хэвлэл мэдээллийн шинэ хэрэгслээс мэдээлэл авдаг уншигчийн тоо улам ихэсч, сурталчлуулахад ч тэр хэвлэл мэдээллийн шинэ хэрэгсэл улам нөлөөтэй болж байна. Бид одоогийн бүтээгдэхүүнээ сайжруулж, шинэ хувилбарыг бий болгоход уншигчдын хэрэгцээг ойлгох шаардлагатай.
2. ХМХ-ийн үүргийг тойруу замаар гүйцэтгэж хэрэглэгчидтэй шууд харилцаа тогтоохын тулд сурталчлуулагч CRM хэрэгжүүлэхийг Шинэ хувилбар эрж хайх гэж нэрлэнэ. Бид сурталчлуулагчид илүү үр нөлөөтэй үйлчлэхийн тулд хэрэглэгчтэй тогтоосон харилцаагаа илүү үр дүнтэй ашиглах хэрэгтэй.

CRM нь хэвлэн нийтлэгчдэд хамгийн үнэ цэнэтэй хэрэглэгчээ тодорхойлж, сонгож, олж авч, хөгжүүлж, холбоогоо хэвээр үлдээхэд тусална.

Хэвлэн нийтлэгчид мэдээллийн сангийн системийг авч ашигласнаар зах зээлийнхээ хэтийн төлвийг олж мэдэхээс гадна хамгийн боломжтой уншигч, зар сурталчилгааны ашгийг таньж мэдэх бололцоо олж авна. Тухайлбал:

-Энэхүү мэдээллийн санг яваандаа ашиглаж болох агаад сурталчлуулагчдад зорилтот хэрэглэгчээ тодорхойлоход, мөн хэвлэн нийтлэгчдэд сонгосон зорилтот бүлэгтээ зориулж шинэ үйлчилгээ боловсруулах, борлуулах, түгээх боломж олгоно.

-Энэ мэдээллийн сан нь шинэ уншигчтай холбоо тогтоох захиалгын системийн баазыг бүрдүүлж, сонин сэтгүүлийн хэвлэлтийн тоог нэмж, захиалагчаа хэвээр үлдээж, алдахгүй байхад ач холбогдолтой юм.

- Үүний зэрэгцээ тухайн компанийн мэдээллийн санг зар сурталчилгааны зах зээлийг бий болгоход ашиглаж болохоос гадна хэвлэл мэдээллийн хэрэгслийн зардал тэр дундаа өрсөлдөгчийнх төдийгүй маркетингийн бусад зардлыг ч ойлгож мэдэхэд ашиглаж болно.

- CRM хэвлэн нийтлэгч, уншигч, сурталчлуулагчийн хоорондын харилцааг ихээхэн дэмждэг. Ингэснээр

уншигчийн хэрэгцээ шаардлагын талаарх эргэх холбоо сайжруулж, агуулгын шинэ санааг өдөөж, зар сурталчилгааны борлуулалтыг нэмэгдүүлэхийн тулд уншигчийн зан төлөвийг судлах чадварыг улам дээшлүүлдэг.

Одоогоор олон хэвлэн нийтлэгчид редакцийн номын сан, архив, бизнес лавлах, айл өрхийн мэдээллийг нэг эх сурвалжийн системд нэгтгэж байна. Ингэснээр сэтгүүлчдэд мэдээ нийтлэл боловсруулахад ихээхэн дөхөмтэй болсон төдийгүй шинэ бүтээгдэхүүн болгон худалдах боломжтой үйлчилгээний агуулгыг боловсруулахад сэтгүүлчдэд тусалж байна.

CRM нь хэвлэн нийтлэгчдэд зөвхөн одоогийн хэрэглэгчийн урсгалаа хадгалах боломж олгоод зогсохгүй ХМХ-ийн дараагийн үеийн бүтээгдэхүүний үндсийг тавьж байна.

CRM СОНИНЫ БИЗНЕСТ НӨЛӨӨЛӨХ ҮНЭ ЦЭНЭ

CRM-ийн үнэ цэнийн талаар сонирхож байгаа хүн дараах зүйлийг анхаарах хэрэгтэй:

- Шинэ уншигчийг татах нь хуучныгаа хадгалж үлдэхээс 10 дахин илүү үнэтэй,
- Хэрэглэгчээ хадгалж үлдэх байдал 10-15 хувиар нэмэгдүүлбэл ашиг хоёр дахин нэмэгдэнэ.

1989 оны үетэй харьцуулахад 2004 онд энэ сэдвийн талаар ХМХ-д 14 мянга гаруй удаа дурдсан байна.

Бэйн болон Компанийн дэлхийн менежментийн хэрэгслийн судалгаанаас үзэхэд CRM нэвтрүүлэх эрмэлзэлтэй дээгүүр албан тушаалтны тоо 2001 онд 72 хувьтай байжээ. Энэ нь жилийн өмнөхөөс хоёр дахин нэмэгдсэн гэсэн үг юм.

CRM нь сонин бизнес ямар ашиг тустай болох талаар асуулт тавьж байгаа хүн дараах зүйлийг анхаарна уу:

- Нэг сонин зар сурталчилгааны дагуу холбоо барьсан хүмүүсийн тоог 50 хувиар, сурталчлуулагчаа 30 хувиар тус тус нэмэгдүүлжээ.
- Хуулийн албанд ирдэг зарга, маргааны тоог 30 хувиар бууруулсан байна.
- Өөр нэг сонин вэб хуудас хэрэглэгчдийнхнээ и-мэйл хаягаар 70 мянган захиалагчтай болсон байна.
- Бас нэг сонин хуучин уншигчаа хадгалж үлдэх хэмжээгээ салбарын дунджаас 60-94 хувиар нэмэгдүүлжээ.
- Сонины интернэт уншигчдыг хэвлэмэл бүтээгдэхүүн захиалагч болгон хувиргахад захиалагчдыг татах уламжлалт аргад зориулдаг зардлын арав хуваасны нэгтэй тэнцэх зардал гарсан.



World Association of Newspapers

Эх сурвалж: Дэлхийн сонинуудын холбоо
Дэлгэрэнгүйг: <http://www.wan-press.org/recherche.php3?recherche=CRM>

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт/цензур/ тогтоохгүй. /Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, 3 дугаар зүйл, 1 дэх хэсэг/

Далайд дусал

МЭДЭЭЛЭЛ БОЛОН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД

1970-аад оны дунд үеэс Мэдээлэл, холбооны технологи (Information Communication Technologies - ICT) болон тэдгээрийг хөгжилд ашиглах нь аажим аажмаар нэмэгдэж байсан юм. АНУ болон баруун Европын хэд хэдэн орон мэдээллийн нийгэмтэй болсон байна. Өөрөөр хэлбэл мэдээллийн программ хангамж болон техник хангамжийг түгээх, боловсруулах, үйлдвэрлэх зэрэг нь эдгээр орны гол үйл ажиллагаа болсон юм (Рожерс 1986 он). **Мэдээлэл Холбооны Технологи (МХТ)** нь электроник утгаараа мэдээлэл солилцох, хадгалах, боловсруулах, цуглуулах үйл явцыг хэлнэ (Хикс 1999). Тоон мэдээлэл холбооны технологи нь мэдээллийн нэг болон тэг хэлбэрт хадгалж, өгөгдлийг цахилгаан холбооны сүлжээгээр дамжуулдаг байна. Мэдээлэл нь электрон дохио хэлбэрээр байдаг, мөн электрон соронзон долгионоор дамждаг аналого системтэй радио, телевиз зэрэг нь мэдээлэл холбооны “хуучин” технологи юм. Дижитал буюу тоон **МХТ** гэдэгт утас, утасгүй үүрэн телефон утас, мэдээлэл холбооны хиймэл дагуул, компьютер болон интернет багтана. Эдгээр технологиуд 1975 оноос эхлэн гуравдагч ертөнц буюу хөгжиж буй оронд өргөн дэлгэрч эхэлсэн. 1970, 1980-аад оны **МХТ**-ийн жишээнд Энэтхэгийн Хиймэл дагуул, Сургалтын телевизийн туршилт, Индонезийн Палапа туршилт, Перугийн хөдөө орон нутаг дахь хиймэл дагуул суурилсан телефон утасны туршилт зэргийг дурдаж болно.

Өнөө үед төлбөртэй утас, факс, бичиг баримт хувилах зэрэг үйлчилгээ үзүүлдэг холбооны төв (Public Call Offices PCO) өргөн дэлгэрсэн байна. Холбооны төв нь гуравдагч ертөнцийн зарим орон нутагт, мөн төв суурин газар хамгийн их дэлгэрсэн. Телетөв буюу өндөр хүчин чадалтай техник хэрэгслээр мэдээлэл холбооны үйлчилгээ үзүүлдэг төв болох энэ загвар хараахан өргөн дэлгэрээгүй байна. Теле төв нь холбооны төвийн үйлчилгээ үзүүлэхээс гадна интернетэд холбогдсон компьютертэй бөгөөд үүгээр цахим шуудангийн үүрэг гүйцэтгэж, цахим хуудас ашиглах бололцоо олгодог байна. Гуравдагч ертөнцийн ихэнх том хотод телетөв эсвэл интернет кафе ажилладаг ч хөдөө орон нутагт энэ загвар хараахан өргөн дэлгэрээгүй байна. Холбооны төв болон телетөв, мөн интернет кафе нь гуравдагч ертөнцийн төв суурин, хөдөө орон нутагт нэн шаардлагатай цахилгаан холбоо, мөн мэдээлэл холбооны бусад үйлчилгээг хүргэхэд үр нөлөөтэй болох нь батлагдсан (Талеро болон Годит 1996). Хөгжиж буй оронд цахилгаан холбоог хэрхэн ашиглаж байгаа, түүний олон хэрэглээг тодотгож өгөх замаар хөдөө орон нутгийн нэгдсэн хөгжлийг **МХТ** дэмжигчид сайшааж байна (Барр 1998:154-56).

- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, загас, гар урлалын бүтээгдэхүүн, бараа бүтээгдэхүүнээ борлуулах зах зээл олж авах, тэдгээрийн үнийг тохирох, тээврийн хэрэгслээ захиалах,
- Түүхий эд материал, хангамжийн зүйлс болон техник тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг зохион байгуулах,
- Хэрэглээний хандлага, бараа бүтээгдэхүүн, үнэ, зах зээлийн талаар шуурхай мэдээлэл олж авч түгээх,
- Мөнгөн хадгаламж, төлбөрийн тооцоо, бэлэн мөнгө хүлээж авах зэрэг санхүүгийн гүйлгээ хийх,
- Хөдөө орон нутаг болон эко-аялал жуулчлалыг хөгжүүлэх,
- Зайны сургалт зэрэг иргэдэд боловсрол олгох боломжийг нэмэгдүүлэх
- Теле эрүүл мэндийн үйлчилгээг хөгжүүлэх. Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой мэдээлэл, өвчний оношлогоо, алслагдсан газрын эрүүл мэндийн төвийн ажилтнуудыг сургах зэрэг мэдээлэл үүнд багтана,
- Хамаатан садан, анд нөхөд, гэр бүлийн гишүүдтэй шууд холбоотой байх боломж бүрдүүлэх.

Орон нутгийн хөгжилд интернетийн гүйцэтгэх үүрэг

Интернет 1990-ээд онд гуравдагч ертөнцийн орнуудад нэвтэрсэн. Хөгжиж буй олон оронд интернет төдийлөн хүчтэй нэвтрэхгүй хэдий ч хот суурин газар **МХТ** өргөн нэвтэрсэн байна. Хөгжиж буй орны хөдөө орон нутгийн хөгжилд мэдээлэл, холбооны технологи чухал ач холбогдолтой юм. Ихэнх хөгжиж буй орны өнөөгийн нийгэм, эдийн засгийн нөхцөлд интернетийн давуу талыг зөвхөн хувь хүн төдийгүй жижиг дунд аж ахуйн нэгж, ТББ, хөгжлийн асуудал хариуцсан төрийн албан тушаалтнууд, орон нутгийн эрүүл мэндийн төв, хөгжилтэй холбоотой асуудал хариуцсан бусад байгууллага хүртэх юм (Ричардсон 1986).

1. Хөдөө аж ахуй эрхэлдэг газар нутагт интернет нь дэлхийн зах зээлд нэвтрэх, мэдээлэл олж авах гарц болох юм. Сайн зохион байгуулагдсан хэрэглэгчид тухайн нутаг дэвсгэрийн хэрэгцээ шаардлага, бодит байдал хамаатай мэдээллийг авах боломжтой. Коммунисти радио, хоршооллын компьютер, дэлгүүр зэрэг одоо байгаа сувгаар тухайн нутаг дэвсгэрийн ард иргэдэд шинэ мэдээллийг хүргэх бөгөөд хүмүүс хоорондын интернет сүлжээг мэдээллийн эх сурвалж, мөн мэдээллийн эрэл хайгуулын хэрэгсэл болгон ашиглаж болно.

2. Тухайн нутаг дэвсгэрийн хөгжилд интернет нь дараах үүрэг гүйцэтгэнэ: орон нутгийн хэрэгцээ шаардлагад тохирсон хэрэглээ, үйлчилгээг бий болгох, амжилттай хэрэгжсэн хөгжлийн стратегийн талаар мэдлэг олгох, дэлхийн, үндэсний, бүсийн байгууллагын үр нөлөөтэй хүч хармайлтын талаар, хөдөө орон нутгийн залуучууд хот суурин газрын үе тэнгийнхнийхээ адилаар мэдээлэл, технологитай танилцаж, компьютерийн талаар суралцах (Ричардсон 1998 б: 174). Хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд интернетийг гадаад ертөнцтэй танилцах цонх мэт ашиглаж, хийсэн ажлаа нийтэлж, хандивлагчдыг эрж хайх боломжтой бол эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд интернетийг техникийн мэдээлэл олж авахад ашиглаж болно. Түүнчлэн интернетийг ашиглан тухайн орон нутгийн мэдээллийг шуурхай хүлээж авах боломжтой бөгөөд тухайн орон нутгийн талаар гарч байгаа мэдээлэл нь үнэтэй эх сурвалж болох юм. Мексикийн чиапас индиан омгийнхон интернет ашиглан олон улсын дэмжлэг авсан нь үүний нэг жишээ юм.

3. Хот суурин газар суугаа шийдвэр гаргагчдад хөдөө орон нутгийн судалгааны дүнг илгээх, доороосоо дээшээ чиглэсэн мэдээллийн урсгалд оролцооны, холбооны аргууд нь чухал үүрэг гүйцэтгэнэ. Орон нутгийн иргэдийн мэдлэгийг дээшлүүлэхэд интернет нь үр нөлөөтэй мэдээ баримт болоод зогсохгүй гадны хүмүүстэй харилцан мэдлэг, туршлага солилцох бололцоо олгох бөгөөд орон нутгийн иргэд байгууллагын дунд мэдээллийн хэвтээ урсгал бий болгоно.

4. Жижиг бизнес эрхлэгчид шинэ зах зээл, чухал бизнес болон санхүүгийн мэдээллийг интернетээр авах боломжтой.

5. Үндсэндээ хөгжиж байгаа орнууд интернетийг харилцан мэдээлэл солилцоход ашиглаж болно. Олон улсын мэдээллийн урсгал голдуу өрнөдийн капиталист орнуудаас гуравдагч ертөнцийн орнуудад чиглэсэн байдаг бөгөөд мэдээллийн урсгал хөгжиж буй орноос өрнөдийн орнуудад чиглэхгүй байна гэсэн шүүмжлэл гарч байгаа юм. Хөгжиж буй орнуудад харилцан мэдээлэл солилцох үр нөлөөтэй 2 суваг байна. Интернет нь гуравдагч ертөнцийн онцгой ашиг сонирхол бүхий бүлэг, сонин хэвлэл, орон нутгийнхан өөрсдийн үзэл бодол, оюун санаа, мэдээллээ гадаад ертөнцөд илгээхийн зэрэгцээ гадаад ертөнцөөс мэдээ, мэдээлэл авч болох юм.

Эх сурвалж: “Гуравдагч ертөнцийн хөгжлийн мэдээлэл холбоо” номноос

Бэлтгэсэн: Г.Нарангарав

